

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 4 дүгээр сар

- Мөнгөний нийлүүлэлт өмнөх сард 0.6%-иар буурсан бол энэ сард 1.8%-иар өсч 12.4 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт сүүлийн 2 сар дараалан саарч 18.0%-д хүрэв.
- 2017 оны эхнээс төгрөгийн харилцах, хадгаламж өсч, валютын харилцах, хадгаламж буурсан хэвээр байна.
- Хадгаламжийн байгууллагаас гадуурх болон банкуудын касс дахь бэлэн мөнгө өсч, Төв банк дахь харилцах буурав. Нөөц мөнгө өсч 2.8 их наяд төгрөг болжээ.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл 3 сар дараалан өсч 12.7 их наяд төгрөгт хүрэв. Үүний 51.8 хувь нь хувийн хэвшилд, 47.6 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 7.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.6 хувь нь чанаргүй зээл байна.

## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2016		2017			
	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>						
<b>Нөөц мөнгө, сая ₮</b>	3,487,656.0	2,712,102.5	2,675,173.0	2,749,861.6	2,779,941.0	
сарын өөрчлөлт, хувиар	-1.7	-11.5	-1.4	2.8	1.1	
жилийн өөрчлөлт, хувиар	38.4	17.5	15.9	17.0	-7.0	
<b>M2 мөнгө, сая ₮</b>	12,076,501.7	11,880,661.8	12,257,201.8	12,189,279.9	12,410,158.3	
сарын өөрчлөлт, хувиар	3.0	-1.6	3.2	-0.6	1.8	
жилийн өөрчлөлт, хувиар	20.2	20.6	22.4	20.5	18.0	
<b>Бусад хадгаламж, сая ₮</b>	9,986,377.6	9,928,266.8	10,112,179.4	10,106,185.8	10,138,360.4	
сарын өөрчлөлт, хувиар	1.9	-0.6	1.9	-0.1	0.3	
жилийн өөрчлөлт, хувиар	19.4	20.5	19.1	18.5	14.8	
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮</b>	823,629.3	736,068.2	944,705.5	788,251.9	834,150.2	
сарын өөрчлөлт, хувиар	7.1	-10.6	28.3	-16.6	5.8	
жилийн өөрчлөлт, хувиар	16.6	3.1	44.1	19.7	12.0	
<b>Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮</b>	12,422,235.9	12,379,495.2	12,583,529.0	12,678,043.4	12,706,689.3	
сарын өөрчлөлт, хувиар	-2.3	-0.3	1.6	0.8	0.2	
жилийн өөрчлөлт, хувиар	6.1	5.0	8.1	7.1	9.2	
<b>Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮</b>	1,051,680.5	1,056,150.4	1,070,100.6	1,035,475.9	1,087,258.3	
сарын өөрчлөлт, хувиар	-9.9	0.4	1.3	-3.2	5.0	
жилийн өөрчлөлт, хувиар	20.9	18.1	17.5	7.0	1.3	
<b>Мөнгөний үржүүлэгч</b>	4.0	4.4	4.6	4.4	4.5	
<b>Банк хоорондын зах</b>						
<b>Илүүдэл нөөц, сая төгрөгөөр</b>	-24.0	-62.9	-36.5	-58.7	-23.8	
сарын өөрчлөлт, хувиар	50.3	-162.3	42.1	-60.9	59.4	
<b>Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт</b>	-5,955.0	-39,316.6	5,823.3	-24,819.1	-12,738.5	
сарын өөрчлөлт, хувиар	81.4	-560.2	114.8	526.2	48.7	
<b>Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ON + ТБҮЦ</b>	530,470.2	329,615.4	510,237.6	895,349.6	1,166,964.2	
сарын өөрчлөлт, хувиар	-40.0	-37.9	54.8	75.5	30.3	
<b>Хөтөлбөрийн зээл, сая төгрөгөөр</b>	1,055,552.2	1,059,646.1	1,089,575.6	1,113,543.9	1,149,788.3	
<b>Хүү (хувиар)</b>						
<b>Хадгаламжийн ЖДХ</b>	13.1	13.4	13.3	13.0	13.0	
Хадгаламжийн бодит хүү*	12.6	12.0	11.9	10.7	10.7	
<b>Зээлийн ЖДХ**</b>	19.7	20.2	20.1	20.2	20.0	
Ипотекийн зээлийн хүү	10.3	9.6	10.3	10.3	10.5	
ТБҮЦ-ны ЖДХ	14.5	14.0	14.0	14.0	14.0	
Бодлогын хүү	14.0	14.0	14.0	14.0	14.0	
БХЗ-ын ЖДХ	15.5	14.5	14.9	15.0	15.0	

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

## Мөнгөний нийлүүлэлт

М2 мөнгөний нийлүүлэлтийн 52.8%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 18.5%-ийг валютын хадгаламж, 13.5%-ийг төгрөгийн харилцах бүрдүүлж байна.


М2 мөнгөний жилийн өсөлт 2017 оны 2 дугаар сард 22.4% байсан бол 3 дугаар сараас эхлэн буурч 20.5%, 4 дүгээр сард 18.0%-д хүрч саарав. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж болон харилцахын өсөлт бүрдүүлж байна. Гадаад валютын харилцах, хадгаламж өнгөрсөн оны сүүлийн саруудад М2 мөнгөний өсөлтийн ихэнхийг бүрдүүлж байсан бол 2017 оноос хойш өсөлтөд оруулах хувь нь буурсаар байна. Энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарч байгаатай холбоотой байна.

Тухайн сард М2 мөнгөний нийлүүлэлт 1.8% (220.9 тэрбум төгрөгөөр)-иар өсч 12.4 их наяд төгрөгт хүрэв. Үүнд М1 мөнгө 9.1%-иар өссөн нь голлон нөлөөлөв.


М1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 147.4 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 41.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Бусад хадгаламж, харилцахын өөрчлөлт харьцангуй бага буюу 0.3 хувиар өссөн боловч бүрэлдэхүүн хэсгүүдийг харвал төгрөгийн хадгаламж 88.4 тэрбум төгрөгөөр өсч, валютын хадгаламж 47.1 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 9.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.


Зураг 1. М2 жилийн өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)



Зураг 2. М2 сарын өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)




Зураг 3. М2 сарын өөрчлөлт, тэрбум ₮



Гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 2017 он гарснаас хойш буурсаар байна. Энэ нь сүүлийн саруудад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чангаралттай холбоотойгоор гадаад валютаас төгрөг рүү шилжих шилжилт болон валютын хадгаламжийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн буурч байгаатай холбоотой байна.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж 3.1%-иар буурсан бол байгууллагын валютын хадгаламж 5.2%-иар өсчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас ойролцоогоор 2.0%-иар буурсан бол, байгууллагынх 6.5%-иар өсчээ.

Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)




### Хадгаламжийн байгууллагын гадаад, дотоод актив

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 580.3 тэрбум төгрөгөөр өсч, дотоод цэвэр актив 359.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив 318.7 тэрбум төгрөгөөр, бусад хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 261.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.


Дотоод цэвэр авлага өмнөх сараас 200.0 тэрбум төгрөгөөр буурч 17.3 их наяд төгрөг болжээ. Засгийн газраас авах цэвэр авлага 194.9 тэрбум төгрөгөөр, хувийн хэвшлээс авах авлага 70.1 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн байгууллагаас авах авлага 27.5 тэрбум төгрөгөөр буурсан бол иргэдээс авах авлага 97.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Тайлант сард нөөц мөнгө (банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын касс дахь бэлэн мөнгөний нийлбэр) 30.0 тэрбум төгрөгөөр өсч 2779.9 тэрбум төгрөг болжээ. Банкуудын Төв банк дахь харилцах 15.8 тэрбум төгрөгөөр буурсан бол хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 4.6 тэрбум төгрөгөөр, банкуудын касс дахь мөнгө 41.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 6. Нөөц мөнгө



### Хадгаламжийн байгууллагын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл 3 дахь сардаа дараалан өсч өмнөх сараас 28.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 12.7 их наяд төгрөг болжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 51.8 хувийг хувийн хэвшилд, 47.6 хувийг иргэдэд, 0.6 хувийг бусад салбарт олгосон зээл байна.


Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сарын түвшинд буюу 7.9 хувьд байна. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.4 нэгж хувиар нэмэгдэж 8.6 хувьд хүрэв. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.1 хувийг эзэлж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн 84.0 хувь, чанаргүй зээлийн 80.0 хувь нь хувийн хэвшилд олгосон зээл байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 8. Хадгаламжийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



### Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 875.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 72.6 хувийг овернайт зээл, 16.2 хувийг репо арилжаа, 6.5 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 4.7 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 5 дугаар сарын 9-ний өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах, төлбөр тооцоо, гүйлгээний зорилгоор 2224.5 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, 1538.5 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.



### Хүү


Тухайн сард төгрөгөөр олгосон зээлийн хүү 20.0% байна. Харин нийт төгрөгийн зээлийн үлдэгдлийнх 0.8 нэгж хувиар буурч 17.7% - д хүрчээ. Тайлант сард олгосон валютын зээлийн хүү 1.9 нэгж хувиар өсч 13.1%-д хүрсэн бол үлдэгдлээр жигнэсэн валютын зээлийн хүү нь бага зэрэг буурч 11.7% болжээ.

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Тайлант сард төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх жигнэсэн дундаж хүү өмнөх сарын түвшинд буюу 13.0%-д байгаа бол тухайн сард татсан хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар буурч 12.7%-д хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хүү бага зэрэг буурч 5.9%-д хүрсэн бол тухайн сард татсан валютын хадгаламжийнх 1.1 нэгж хувиар буурч 4.3% болжээ.

Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



## Валютын ханш

2017 оны 4 дүгээр сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1.1 хувь буюу 28.0 төгрөгөөр чангарч 2419.4 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2421.8 төгрөг байв. 2017 оны 4 дүгээр сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2633.7, Хятадын юаньтай харьцах ханш 350.7, ОХУ-ны рубльтай харьцах ханш 42.5 байв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 0.9%-иар өссөн буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр чангарсан байна.

Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100

